



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын их сургуулийн Шинжлэх Ухааны Сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэл, орон судлал (Франц)

Индекс: D023102

Шинжээчийн баг:

Ахлагч:	С.Эрдэнэтуул	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Академик чиглэл хариуцсан дэд захирал, доктор
Гишүүд:	О.Оюунбилэг	Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын шинжээч
	Б.Оюунцэцэг	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч, доктор

Он сар өдөр: 2021.12.06

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	14
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	17
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	20
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	22
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	
I. Багш нарын нэрс	28
II. Оюутнуудын нэрс	28
III. Ажил олгогчдын нэрс	29
IV. Төгсөгчдийн нэрс	29
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	30
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

БНМАУ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс

БНФУ

Бүгд Найрамдах Франц Улс

БМИҮЗ

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

БСШУСЯ

Боловсрол Соёл Шинжлэх ухаан Спортын Яам

БСШУЯ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам

БШУЯ

Боловсрол, Шинжлэх ухааны яам

ГХСС

Гадаад Хэл Соёлын Сургууль

МУИС

Монгол Улсын Их Сургууль

НҮБ

Нэгдсэн Үндэстний Байгууллага

ОУХС

Олон Улсын Харилцааны Сургууль

ОУ

Олон Улс

ТББ

Төрийн бус байгууллага

ХХК

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХЧБХ

Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс

ШУС

Шинжлэх Ухааны Сургууль

ЭЕШ

Элсэлтийн ерөнхий шалгалт

ЭСЯ

Элчин сайдын яам

Англи хэлээр

PDCA

Plan Do Check Act

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын их сургуулийн Шинжлэх Ухааны Сургууль School of Arts and Sciences, National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Гадаад хэл, орон судлал (Франц) Foreign Languages and Area Studies (French)	
Индекс	D023102	
Шинжээчид	<p>Шинжээчийн багийн ахлагч: С.Эрдэнэтуул - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Академик чиглэл хариуцсан дэд захирал, доктор</p> <p>Шинжээчийн багийн гишүүд: О.Оюунбилэг – БШУЯ-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын шинжээч Б.Оюунцэцэг – БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч, доктор</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал – Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2021.11.17	/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/ Урьдчилсан үнэлгээний тайланг сургуульд хүргүүлэх
	2021.11.22 – 11.23	Сургууль дээр ажиллаж, оролцогч талуудтай уулзаж, нотлох баримтуудтай танилцах
	2021.12. 06	Шинжээчийн багийн тайланг БМИҮЗ-д хүргүүлэх
	2021.12.10	Шинжээчийн тайланг БМИҮЗ-ийн мэргэжилтэн сургуульд хүргүүлж, сургуулийн саналыг авах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Анх 1961 онд Монгол улс НҮБ-ын гишүүн болсноор БНМАУ-ын гадаад харилцаа өргөжиж, франц хэлтэй мэргэжилтний эрэлт хэрэгцээ нэмэгдсэн учир МУИС франц хэлтэй мэргэжилтнийг дотооддоо бэлтгэж эхэлсэн. Тус хөтөлбөрийг 1963-1990 онд Хэл бичгийн факультетын гадаад хэлний тэнхим, 1991-1993 онд ОУХС-ийн Франц-герман хэлний тэнхим, 1993-2000 онд ОУХС-ийн Франц хэлний тэнхим, 2000-2013 онд ГХСС-ийн Франц судлалын тэнхим, 2013 оноос өдгөө хүртэл ШУС-ийн Европ судлалын тэнхим хариуцан ажиллаж иржээ. Сургалтын төлөвлөгөөг 2002, 2008, 2015, 2021 онуудад шинэчлэн батлуулж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

2021-2022 оны хичээлийн жилд Олон улс, орон судлал (Франц) хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим нь франц хэлний мэргэжлийн 4 үндсэн, 1 цагийн багштайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас гадна 1 зочин багшийг гэрээгээр ажиллуулж байна. Үндсэн багш нарын хувьд 100 хувь докторын зэрэгтэй, 1 багш профессорын, 2 багш дэд профессорын, 1 багш ахлах багшийн албан тушаалд ажиллаж байна.

Жилд ойролцоогоор 30 орчим суралцагчийг элсүүлж, тэдний 50-60 хувь нь хугацаандаа төгсдөг байна. Хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлт 70-80 хувьтай байгаа бөгөөд дийлэнх нь мэргэжлээрээ ажиллаж байна. Төгсөгчид аялал жуулчлалын салбар, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүд, олон улсын бизнес эрхэлдэг жижиг дунд бизнесийн байгууллагад гол төлөв ажиллаж байгаагаас гадна жилд 1-3 төгсөгч гадаадад магистрантурт үргэлжлүүлэн суралцаж байна.

Тайлант хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд 22 илтгэл хэлэлцүүлж, нийт 16 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэнээс Web of science мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд 1, ОУ-ын эрдэм шинжилгээний сэтгүүлд 7 өгүүлэл хэвлүүлсэн байна. Түүнчлэн 3 багш докторын зэргээ амжилттай хамгаалсан нь багшлах боловсон хүчний хувьд хамгийн том дэвшил байлаа.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын санаачилгаар 2018 оны 6 сард “Франц хэлтэн орнуудын инновац, хамтын ажиллагааны төв” буюу АЮФ байгуулагдаж, гадаад хэлний сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, ном, хэвлэлийн хүртээмж нэмэгдсэн. Тус төвд оюутнууд бие даан болон багаар ажиллах, франц хэлт багш, оюутнуудтай холбоо тогтоох, олон улсын онлайн номын сангаас мэдээлэл авах боломжоор хангагддаг.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Олон улс, орон судлал (Франц) хөтөлбөрийг PDCA циклийн дагуу тасралтгүй сайжруулалт хийж байна. МУИС – ийн хөтөлбөрийн хорооноос 2013 онд гадаад хэлний хөтөлбөрт хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн, 2014 онд хөтөлбөр сайжруулах нийтлэг зөвлөмжийг тэнхимүүдэд хүргүүлэн, 2015 онд хөтөлбөрийн шинэчлэлт хийсэн.
- Хөтөлбөрт хамгийн сүүлд хийсэн өөрчлөлтөөр хөтөлбөрийн төгсөгчийн загварыг баталж, суралцахуйн зорилтот үр дүнгүүдийг тодорхойлсоны зэрэгцээ хөтөлбөрийн матрицыг гарган, хичээл хоорондын уялдаа холбоог тодорхойлсон.
- Хөтөлбөрийн STEEP шинжилгээг хийж, ажил олгогчдын судалгааны үр дүнд тулгуурлан, төгсөгчийн загвараа тодорхойлсон.
- Олон улсын түвшинд Стэнфордын их сургууль, Бритиш Колумбын их сургууль, Миннесотагийн их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн STEEP шинжилгээг хийж, хөтөлбөрт байнгын сайжруулалт хийж байна.
- Гадаадын сургуулиудын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулалт хийж, давуу, сул талаа дүгнэснээс гадна тэднээс бенчмаркинг хийх чиглэлээ тогтож, хөтөлбөртөө шингээсэн.
- Үндсэн мэргэжлээс гадна тухайн суралцагчийн төгсөөд ажиллах салбартай уялдаатайгаар бусад хөтөлбөрийн хичээлүүдээс сонгох боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Төгсөгчид, ажил олгогчдын төлөөлөлтэй уулзахад, салбар салбарын орчуулгын мэдлэг, чадварыг олгох тал дээр анхаарахыг санал болгосон.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- “Гадаад хэл, орон судлал (Франц)” хөтөлбөрийн зорилго нь “Хэл, соёл, нийгэм, хүмүүнлэгийн салбарт орчин үеийн чиг хандлагад нийцсэн Европын олон хэлний суурь хөтөлбөрийн стандартын харгалзах түвшингийн мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэхэд оршино.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тодорхойлж, суралцахуйн зорилтот үр дүнг хэлний болон орон судлалын мэдлэг, хэлэхүйн болон орон судлалын чадвар, хандлага гэсэн бүлэгтэйгээр тодорхойлсон.
- Ажил олгогчийн зүгээс төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлага хангалттай сайн гэж дүгнэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн стратеги, бүрэлдэхүүн сургуулийн стратеги уялдаа холбоотой тодорхойлогдсон.
- Төгсөгчидтэй ойр ажиллаж, тэдэнд дутагдаж буй мэдлэг, ур чадварын талаар тодруулга авч, хамтран ажилладаг нь уулзалтын явцад нотлогдсон.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь Монголд үйл ажиллагаа явуулж буй франц хэлтнүүдийн төлөөлөл болон Францын олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажилладаг нь тухайн хөтөлбөрийн салбартаа танигдах боломжийг дээшлүүлж, хөтөлбөрийн чанарт эерэгээр нөлөөлж байна.
- Ажил олгогчдын судалгаа, ярилцлагаас харахад, төгсөгчдийн хувьд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад хэл, орон судлал (Франц) хөтөлбөр нь “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу 121 багц цагийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн бүлгүүдийн хичээлүүдийг тусгаснаас гадна энэхүү бүлгүүдийн харьцаа шаардлагад заасны дагуу тодорхойлогдсон байна.
- 2015 оноос хойш 2017, 2021 онуудад сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. Хөтөлбөрийн индексийг 2017 онд шинэчлэн батлуулсанаас гадна “Гамшгаас хамгаалах менежмент” 1 багц цагийн хичээлийг ерөнхий суурь хичээлийн бүлэгт нэмэлтээр оруулсан.
- 2015 онд хөтөлбөрийг шинэчлэн баталж, чөлөөт сонголтын 15 багц цагийг оюутанд санал болгон, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг олгосон.
- Сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлүүдийн хөтөлбөрийг боловсруулах сайжруулсан загварыг хэрэглээнд оруулсан.
- Сургалтын үр дүнд чиглэсэн арга зүйг хичээлийн хөтөлбөрт тусгаж өгсөн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тодорхойлж, хөтөлбөрийн матрицыг боловсруулсаны зэрэгцээ хичээл хоорондын уялдаа холбоог бүрэн зурагласан.
- Хөтөлбөрийн матрицыг боловсруулсанаар агуулгын давхцалд үнэлгээ хийн, мэргэжлийн хичээлүүдийн агуулгад сайжруулалт хийсэн.
- Хичээлийн хөтөлбөрүүдийг нэгдсэн удирдамжийн дагуу боловсруулж, баталгаажуулан хэрэглээнд оруулсан.

Анхаарах асуудал:

- Төгсөгчийн загвартай уялдуулан хөтөлбөрийн матрицыг олон янзаар боловсруулсан байгаа нь ойлгоход төвөгтэй байна.
- Хичээлийн хөтөлбөрт туссан сургалтын арга зүй дийлэнх хөтөлбөрүүдэд адилхан байгаагаас гадна үнэлгээний хэлбэр тодорхой бус байна.
- БШУ – ны сайдын 2020 оны А/262 тоот тушаалын дагуух ерөнхий суурь хичээлийн заалтыг мөрдөх.

Шаардлага:

- Хөтөлбөрийн матрицад туссан ойлголт өгөх түвшний хичээлийг үнэлэх шаардлагагүй гэж үзсэнийг засах. Мэргэжлийн суурь хичээлүүдийн мэдлэгийн түвшинг үнэлэх шаардлагатай гэж үзэж байна. Хичээл бүрийн сургалтын арга зүйн ялгаатай байдлыг тодруулах.
- Хөтөлбөрийн матрицыг олгохыг зорьж буй мэдлэг, чадварыг түвшинчилсэн байдлаар хичээл бүрээр харуулж, нэг л хэлбэрээр боловсруулж, хэрэглээнд оруулах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- 2015 онд хийгдсэн өөрчлөлтөөр оюутанд сонголт хийх боломж нэмэгдэж, бусад хөтөлбөрийн хичээлүүдээс 15 багц цагийг сонгодог болсон.

- Хэлний мэргэжилтэн бэлтгэх хүрээнд зөвхөн гадаад хэл төдийгүй тухайн орны нийгэм, соёл, эдийн засгийн мэдлэг, чадварыг олгох хүрээнд мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүд тодорхойлогдсон.
- Францын түүх, улс төр, эдийн засгийн газарзүй, нийгэм, соёлын хичээлүүдээс гадна орчуулгын онол, олон улс судлалын удиртгал, франц хэлний авиа зүй, хэлзүй, ахисан дунд шат хүртэлх франц хэлний хичээлүүд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан.
- Хэлний хичээлүүд семинараар зохион байгуулагддаг.
-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн нийт агуулгын 70 хувь нь семинарын хичээлүүд бөгөөд хэлний мэдлэг, хэлэхүйн чадвар эзэмшүүлэх багц хэсэг нь Европын зөвлөлөөс эрхлэн гаргасан “Европын олон хэлний суурь хөтөлбөр: сурах, сургах, үнэлэх” бодлогын баримт бичигт үндэслэсэн.
- Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу харьцаанууд тодорхойлогдсон.
- Чөлөөт сонголтоор бусад салбарын мэдлэг, мэдээлэл олж авах боломжтой.
- Дадлагын гэрээт байгууллагууд олонтой, одоогийн байдлаар 12 байгууллагад оюутнуудаа гэрээгээр дадлага хийлгэж байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрүүдэд агуулгын сайжруулалт хийсэн шалтгаан, түүнтэй холбоотой харьцуулсан судалгааг хийх.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах нэгдсэн удирдамжийг МУИС-ийн бүхий л хөтөлбөрүүдэд мөрддөг.
- Хичээлийн хөтөлбөрүүдэд сургалтын арга зүйг нэгдсэн байдлаар тусгаж өгсөн.
- Цахим сургалтын эрх зүйн орчныг бүрдүүлж, цахим сургалтын журам, удирдамж заавраар хангасан.
- Заах арга зүйтэй холбоотой хичээл үзсэн оюутнуудаас авсан санал асуулгын судалгаа хийгдсэн.
- Сургалтын идэвхтэй аргуудыг хичээлд ашиглаж буй байдлын талаар судалгаа хийгдсэн.
- Хэлэхүйн чадварыг эзэмшүүлэх мэргэжлийн лабораторийг ашиглалтад оруулж, оюутнуудын дуудлага, авиазүйг засах дасгалууд хийгдэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын мэдээллийн Сиси системээс гадна Microsoft Teams платформыг цахим сургалтад ашиглаж байна.
- Оюутнуудыг зөв дуудах, дуудлагыг сайжруулах дадлага хийх технологийн боломжит орчныг бүрдүүлсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын хамтын санаачилгаар 2 хичээлийн цахим контент боловсруулагдсан.
- Багш нар цахим хичээлийн өгөгдлийн сантай, арга зүйтэй болсон байна.
- Сургалтын арга зүйн шинэчлэлийг тогтмол хангах багшийн хөгжлийн төвтэй болсон байна.
- Оюутнууд багшийг, хичээлийг сонгох боломж бүрэн шийдэгдсэн.

Анхаарах асуудал:

- Цахим платформын хэрэглээ багш нарын хувьд харилцан адилгүй байна.
- Сургалтын арга зүйд хийсэн судалгаа, шинжилгээний үр дүн ойлгомжгүй байна.

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйд хийсэн судалгааны боловсруулалтыг сайжруулж, шаардлагатай хичээлүүдэд арга зүйн шинэчлэлт хийх.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын журмыг баталж, журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулдаг. Оюутныг үнэлэх, дүгнэх журам хэрэглээнд орсон.
- Төгсөгчийг загварыг суралцагчид олгох мэдлэг, чадвар, хандлага гэсэн цогц чадамж байдлаар тодорхойлон гаргасан.
- Тэнхимийн хүрээнд дүнгийн шинжилгээ хийсэн.
- Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанаас улирал бүр оюутнуудын дүнгийн нэгдсэн үнэлгээг хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхимийн зүгээс өөрийн хөтөлбөрийн хичээл бүрээр дүнгийн шинжилгээ хийж, хэлэлцдэг.
- Сонсох, унших, ярих, бичих чадварыг шалгах төрөл бүрийн үнэлгээний арга зүйг Европын олон хэлний суурь хөтөлбөрийн хүрээнд ашигладаг.

Анхаарах асуудал:

- Сүүлийн 3 жилийн дунджаар оюутны дундаж үнэлгээ буурч байгаа, тухайн хөтөлбөрөөр суралцагчдын голч онооны дундаж бага байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Гадаад хэлний чадварын хувьд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээг нэвтрүүлэх боломжийг хайх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн багш нар хичээлийн 4 ангид сургалт явуулдаг, анги танхим бүр интернет сүлжээнд холбогдсон. Хөтөлбөрийн мэдээллийн технологийн хэрэгсэл сүүлийн 5 жилд нэмэгдсэн. Суурин компьютер 37, олшруулах машин 3, зөөврийн компьютер 2, LCD проректор 8, өсгөгч 2, CD тоглуулагч хөгжим 3, ухаалаг самбар 4, утасгүй интернетийн антен 1, сканер 1 зэрэг техникийн хэрэгслүүдийг ашигладаг.
- Оюутнууд хичээлийн бус цагаар бие дааж болон багаар ажиллах боломжийг бүрдүүлсэн.
- Багш нарт цахимаар хичээл заахдаа Hec-ate G1 веб камер, Hecate G1 чихэвч, Teams програм болон бусад програм ашигладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 оноос “Франц хэлтэн орнуудын инноваци, хамтын ажиллагааны төв” буюу АЮФ байгуулагдсанаар франц хэлний сургалт явуулах, карьер хөгжлийн зөвлөгөө өгөх, оюутан бие даан болон багаар ажиллах таатай орчин бүрдсэн.
- МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын хэлний чиглэлийн тэнхимүүдийг түшиглэн салбар дундын “Авиа зүйн лаборатори” байгуулсан нь хэл шинжлэл, авиазүй, сэтгэл судлал, нейро хэл шинжлэл, хэрэглээний хэл шинжлэлийн салбар дундын судалгааг хөгжүүлэх суурь тавигдсан.
- Хэлмэрчлэхүйн лабораторид орчуулагчийн кабин, төв удирдлагын систем, 32 сонсогчийн төхөөрөмж, тавган антен, IR дохио дамжуулагч байршуулан хэлмэрчлэхүйн хичээлийг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хэлмэрчлэхүй болон авиа зүйн лабораторийн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Цаашид сургалтын орчны талаарх суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг задлан шинжлэх, шаардагдах арга хэмжээг авах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг хэвлэмэл болон электрон байдлаар хүртээмжтэй хангасан.
- Хөтөлбөрийн сурах бичгийн хүртээмж сайн.
- Сургалтын үйл ажиллагаандаа SiSi систем, Microsoft Teams, Moodle, Zoom зэрэг лицензтэй болон Youtube, Google, Facebook зэрэг лицензгүй программуудыг ашигладаг.
- Е-контент түвшинд 2 хичээлийн сургалтын материал боловсруулан МУИС-ийн OpenEdx системд байршуулсан.
- Үндсэн сурах бичиг, гарын авлагын хангамж сайн, суралцагчид сэтгэл ханамжтай байдаг нь уулзалт ярилцлагаас нотлогдсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар хөтөлбөрийн оюутан, франц хэл сонирхогч иргэдэд зориулсан франц хэлний сурах бичиг, толь бичиг, ярианы дэвтэр, гарын авлага зэргийг хэвлүүлэн гаргадаг. Үндсэн сурах бичиг, гарын авлагын хангамж сайн, суралцагчид сэтгэл ханамжтай байдаг нь уулзалт ярилцлагаас нотлогдсон.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн ном, сурах бичиг, фондын бүртгэл, судалгааг хийх, судалгааны үр дүнд фондын баяжуулалтыг хийж байх

Зөвлөмж:

- Сургалт, хичээлийн материал, ном сурах бичгийн Е-контент түвшинд боловсруулах арга барил, бусад их сургууль, гадаад улсын туршлагаас суралцах.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчид орчин үеийн шаардлага, чиг хандлагад нийцсэн МУИС-ийн номын сан, тэнхимийн сан болон АЮФ төвийн номын сангаар үйлчлүүлэх боломжтой.

- МУИС-ийн номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд магистрын ажлыг 100%, докторын судалгааны бүтээлийг 80%-ийн гүйцэтгэлтэй цахим хэлбэрт шилжүүлсэн.
- Багш нар EBSCO, Springer, Jstor зэрэг цахим номын сан ашигладаг.
- Суралцагчдаас шаардлагатай ном, сурах бичгийн хүсэлтийг авч, номын баяжуулалтыг хийдэг.
- Сургуулийн аль ч орчинд интернетэд холбогдох боломжтой бөгөөд JSTOR болон бусад нээлттэй судалгааны сангаас мэдээлэл авах боломж бүрдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, бусад олон улсын байгууллагын тусламжтайгаар тэнхимийн номын сангийн франц хэлний сурах бичгийг нөөцийг бүрдүүлсэн.
- 2018-2019 оны хичээлийн жилд БНФУ-ын ЭСЯ-наас 1500 еврогийн санхүүгийн дэмжлэг авч Танданс /Tendance/ сурах бичгийн А1, А2, В1, В2, С1 түвшний 150 гаруй сурах бичиг худалдан авсан.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба 2017 онд байгуулагдаж 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс /ХЧБХ/ ажиллах журмыг шинэчлэн баталсан.
- SiSi системээр сургалтын бүхий л үйл ажиллагааг хурдан шуурхай, ил тод, талуудын хяналт дор явуулах боломжийг өргөтгөсөн ба хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, сургалтын төлөвлөгөө болон тэнхимийн ажил, төлөвлөгөөнд үндэслэн хөтөлбөрийн төлөвлөлт, хяналтыг хэрэгжүүлдэг.
- Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдал хангах талд анхааран цахим эх үүсвэрүүд, сургуулийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ирсэн баримт.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаа жигдэрсэн.
- МУИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө болон тэнхимийн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд үндэслэн хөтөлбөрийн урт, богино хугацааны төлөвлөлт, хяналтыг хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөртэй холбоотой санал гомдол хүлээн авах сувгийг тодорхой болгох, ирсэн санал гомдлын бүртгэл, шийдвэрлэсэн байдлын судалгаатай болох, судалгааны үр дүнг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцыг оновчтой болгоход тусгаж байх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр нь Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Аллианс Франсез, Антоон Мостаерт монгол судлалын төв, ДМД Монголий, МонголийВояж зэрэг дотоод, гадаадын байгууллагатай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг.
- Сорбоны их сургууль, Дорно дахины хэл, соёлын сургууль зэрэг Францын 7 их, дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулсан.
- Монгол, Францын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд франц мэргэжилтэн багш ажиллуулдаг.
- 2016-2020 онуудад хөтөлбөрийн багш нар гадаадын 8 төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдах, оролцох замаар Франц хэлт орнуудын Инноваци, хамтын ажиллагааны төвийг байгуулах, олон улсын зуны сургалт зохион байгуулах, орчуулгын бүтээл хэвлүүлэх болон E-контентын түвшинд сургалтын материал боловсруулах ажлыг хэрэгжүүлсэн байна.
- Мөн 2016-2020 онуудад дотоодын санхүүжилттэй 14 төсөл, гэрээт ажил гүйцэтгэсэн байна.
- Хөтөлбөрийн багш нарын танилцуулсан нотлох баримт.
- Төгсөгчидтэй хийсэн ярилцлага.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар А.Мостаертын “Авиазүйн өгүүллүүд”, “Ордос толь”, Баабарын “Монголчууд: Нүүдэл, суудал” зэрэг томоохон бүтээлийн орчуулгын ажилд оролцсон.
- Франц хэлтэн орнуудын Инноваци, хамтын ажиллагааны төвийн үйл ажиллагааны хүрээнд нийтдээ 49,260 евро буюу 157 сая 779 мянган төгрөгийн санхүүжилтийг

гаднаас татаж авсан туршлагатай бөгөөд хөтөлбөрийн төгсөгчдөө АЮФ-ийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах онцгой эрхтэй.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах асуудлыг төгсөгчдөөс авч буй судалгааны үр дүнтэй уялдуулан тодорхойлох.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн гол эх үүсвэр нь оюутны сургалтын төлбөр ба сургалтын төлбөрийн хэмжээг жил бүр шинэчлэн тогтоодог. Хөтөлбөрт суралцаж буй оюутны тоо 47. 2020 оны байдлаар хөтөлбөрийн нийт орлого 149 сая 459 мянга 891 төгрөг, зардал 120 сая 911 мянга 177 төгрөг бол зөрүү 28 сая 548 мянга 714 төгрөг байна.
- 2020 онд нэг оюутанд ногдох зардал 3, 654, 236 төгрөг байсан.
- Өөрийн үнэлгээний тайланд хавсаргасан санхүүгийн тоо, баримт.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Профессор багш нарын судалгааны ажлыг дэмжих зорилгоор 2013-2014 оны хичээлийн жилээс “профессорын суурь зардал” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн багш нарын боловсруулсан гарын авлага, сурах бичиг, нэг сэдэвт бүтээлийн тоо нэмэгдсэн байх хандлагатай.

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар хөтөлбөрийн шинэчлэлт, өөрчлөлтөд зарцуулах төсөв, хөрөнгийн талаарх мэдээлэл, зөвлөмжийг сургуулийн захиргаа, санхүүгийн албанаас авдаг байх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, тэдний эцэг, эхчүүдэд элсэлтийн үйл ажиллагааны үеэр сургуулийн цахим хуудас, мэргэжил сурталчлах өдөрлөгөөр дамжуулан хүргэдэг.
- 2015 оноос хойш хөтөлбөрийн багш нар үндэсний телевизэд франц хэл, соёл, уран зохиолын талаар ярилцлага өгч, хөтөлбөрөө сурталчлах уламжлал тогтсон. Тухайлбал, 2019-2020 оны хичээлийн жилд хөтөлбөрийн багш нар Монгол HD, Eagle, MNB, Соёл эрдэм гэх 4 телевизийн 5 удаагийн ярилцлага, нэвтрүүлэгт оролцсон байна.
- Өөрийн үнэлгээний тайлан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар Францын соёлын өдөрлөг, франц хэлнүүдийн баяр, франц дуу, яруу, найргийн уралдааныг Франц, Канад, Швейцар, Бельгийн ЭСЯ-тай хамтран зохион байгуулдаг туршлагатай.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байгаа эсэх талаар Өөрийн үнэлгээний тайланд тодорхой тусгаагүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах зорилгоор сурталчилгаа, маркетингийн судалгаанд онцгой анхаарч судалгааг тодорхой давтамжтай хийдэг болох.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэгчдэд зориулсан сэтгүүл, брошюрыг тогтмол хэвлэн нийтэд нээлттэй тараадаг.
- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангахад МУИС-ийн цахим мэдээллийн орчин, түүний цахим мэдээллийн бүтцийг тогтмол ашигладаг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогч, төгсөгчдийн холбоотой эргэх холбоотой ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар сэтгүүл, брошюрыг тогтмол хэвлэн нийтэд нээлттэй хүргэх арга хэмжээг зохион байгуулах боломжийг судлах.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагаа болон хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой мэдээллийг цаг хугацаа алдалгүй мэдээллийн гол сувгуудаар түгээх.

Шаардлага:

- МУИС – ийн веб хуудасны өөрийн хөтөлбөртэй холбоотой хэсэгт сургалт явуулж буй хөтөлбөрийн талаарх мэдээллийг оруулах.
- Хөтөлбөрийн сургалтын болон сургалтаас гадуурх үйл ажиллагааны талаарх мэдээллээ веб хуудсанд цаг тухайд нь оруулах.
- Төгсөгчдийн холбооны нэгдсэн facebook группээр дамжуулан төгсөгчдийн мэдээллийн санг бүрдүүлэн, судалгааны үр дүн болон бусад мэдээллийг тэдэнд эргэж мэдээлж байх.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийг холбогдох хууль эрх зүй, дүрэм журам үндэслэн зохион байгуулдаг. (Бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам 2018, 2019, 2020)
- Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам
- Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонголтыг баталгаажуулах тухай тушаалууд
- Элсэгчдэд зориулсан гарын авлага, брошур
- Мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулгууд
- МУИС-ийн элсэлт, бүртгэлийн албаны тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийг цахимаар зохион байгуулдаг www.burtgel.num.edu.mn
- Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо 600- аас дээш.
- Элсэлт бүртгэлийн хэлтэс, Хөтөлбөр чанарын баталгаажуулалтын хэлтэс, Оюутан төгсөгчийн хэлтэс, тухайн хөтөлбөрийн багш нар хамтран шинэ элсэгчдэд зориулан чиглүүлэх сургалт зохион байгуулдаг.
- Суралцагчийн гарын авлагыг цахим хэлбэрээр СИСИ системээс татан авах боломжтой.

Анхаарах асуудал:

- Гадаад хэл, орон судлал(Франц) хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаарх вебийн мэдээллийг 2015 оноос хойш шинэчлээгүй

Зөвлөмж:

- МУИС-ийн албан ёсны веб сайт(<https://www.num.edu.mn/>)-д Гадаад хэл, орон судлал(Франц) хөтөлбөрийн талаарх мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж, хөтөлбөрийг ил тод, нээлттэй сурталчилж байх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зөвлөх багш томилох тухай тушаалууд
- Франц хэлт орнуудын их дээд сургуулийн холбоо (АЮФ)-ны Инновац, хамтын ажиллагааны төв, БНФУ-ын ЭСЯ, Франц хэлний монголын багш нарын холбоо зэрэг хамтын ажиллагаатай байгууллагуудтай хийсэн ажлын мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жилд 2 удаа хөтөлбөр сурталчлах өдөрлөг зохион байгуулдаг.
- Хөтөлбөрийн багш нар бие даалттай өдрүүдэд зөвлөгөө, давтлага өгөх хуваарь гарган ажилладаг.
- Тус хөтөлбөрийн оюутнуудад зориулан АЮФ-ийн Инновац, хамтын ажиллагааны төв долоо хоногийн ажлын хуваарь гарган ажилласанаар сургалттай холбоотой нэмэлт зөвлөгөө, давтлага авах боломжтой.
- Гадаад хэл, орон судлал (Франц) хөтөлбөр хариуцсан багш нар АЮФ-ийн Инновац, хамтын ажиллагааны төвтэй нягт хамтран ажиллаж, оюутнуудад зориулсан арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Тухайлбал: “Франц болон франц хэлтэн орнуудад магистрт суралцах боломж”, “Гадаад хэл-амжилтын үндэс” г.м өдөрлөгүүд г.м
- БНФУ-ын ЭСЯ-тай хамтран “Монгол өв соёл” зуны сургалтыг зохион байгуулж, 7 орны 70 гаруй оюутныг хамруулсан.
- Бие хүний харилцаа, эрүүл аж төрөх чиглэлээр 2016-2017 оны хичээлийн жилд 11, 2018-2019 оны хичээлийн жилд 17, 2019-2020 оны хичээлийн жилд 24, 2020-2021 оны хичээлийн жилд 6 үйл ажиллагааг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагаанд хөтөлбөрийн суралцагчид идэвхтэй оролцсон.

Зөвлөмж:

- Суралцагчдад зориулсан аливаа зөвлөн туслах үйлчилгээний үр дүн, ахиц дэвшил, анхаарах асуудлыг тодорхойлж, үйл ажиллагаагаа сайжруулахад ашигладаг байх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Оюутны клуб”-уудын үйл ажиллагаанд Гадаад хэл, орон судлал(Франц) хөтөлбөрийн оюутнуудын оролцооны талаарх мэдээлэл.
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг.
- Тэтгэлэг урамшуулалд хамрагддаг мэдээлэл
- Франц улсад зуны сургалтад хамрагдсан суралцагчдын мэдээлэл
- “Европ судлал” оюутны эрдэм шинжилгээний хурал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрийн оюутнууд “Оюутны сайн дурын клуб”-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Тухайлбал: Nest бүжгийн клуб, Өөрчлөлт клуб, Talent student клуб, Оюун ухааны клуб г.м
- Хөтөлбөрийн оюутнууд АЮФ-ийн Инновац, хамтын ажиллагааны төвийг түшиглэн франц хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор хөтөлбөрийн бус оюутнуудад зориулан Франц дуу сурах, орчуулга хийх, Франц ном унших, Кино клуб г.м сайн дурын клубуудыг байгуулж оюутнуудыг идэвхтэй хамруулдаг.
- Тус хөтөлбөрийн оюутнууд Оюутны хөгжлийн зээлд хамрагдахаас гадна Mitsubishi UFJ сангийн тэтгэлэг, Шинэ Монгол Мабучи сангийн тэтгэлэг, “Ургах наран” ТББ тэтгэлэг, “ДМД” ХХК-ний тэтгэлэгүүдэд хамрагдсан.
- Францын Lyons клубын хэрэгжүүлдэг AMICIF оюутан солилцооны хөтөлбөрт 2015-2019 онуудад 21 оюутан Франц улсад зуны сургалтад хамрагдсан.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам 2019 оны А/483 тоот тушаал
- МУИС-д хичээл дүйцүүлэх журам 2019 оны А/495 тоот тушаал
- Оюутан төгсөгчийн хэлтсийн тайлан
- 2015-2020 оны хооронд тус хөтөлбөрт 14 оюутан шилжин ирж, 30 оюутан шилжиж явсан. Шилжсэн шалтгааны 30 хувь нь дотоодын, 17 хувь нь гадаадын их дээд сургуульд шилжсэн байна. Харин шилжиж ирсэн оюутны 1 нь гадаадаас, бусад 13 нь МУИС-ийн өөр хөтөлбөрөөс шилжин ирсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг Дүн, бүртгэл хариуцсан нэгж, суралцагч, мэргэжлийн тэнхимтэй хамтран зохион байгуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрөөр тогтвортой суралцагчдын хувийг жил бүр тооцоолон, дүн шинжилгээ хийх.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын журам (2015 оны А/203 тоот тушаалаар батлагдсан)
- Төгсөгчдийн тоон мэдээлэл

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр 15-17 оюутан төгсдөг. 2016-2020 онд 70 оюутан төгссөн.
- Жилд 2 удаа буюу хавар, намар төгсөлтийг зохион байгуулдаг.
- Төгсөгчийн дипломыг зохих дүрэм, журамд нийцүүлэн олгодог.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д багш сонгон шалгаруулах, албан тушаалын зэрэглэл тогтоох хөдөлмөрийн дотоод журам, МУИС-д профессор багш ажиллуулах журмыг мөрдлөг болгодог.
- Багшийн судалгаа, эрдэм шинжилгээг дэмжих чиглэлээр судалгааны санхүүжилтийн журам, шагнал урамшууллын нийтлэг журам үйлчилдэг.
- МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөнд “МУИС-ийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хүний хөгжлийг хангах, багш ажилтны тасралтгүй хөгжих орчин бүрдүүлж, идэвх санаачлагатай ажиллах хөшүүрэг бий болгоно” хэмээн тусгасан.
- Шилдэг профессоруудыг ажиллуулах зорилгоор эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээрээ олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн эрдэмтдийг сонгон шалгаруулалтгүйгээр профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллуулахаар тусгасан.
- Хөтөлбөрийн үндсэн 4 багш 100 хувь докторын зэрэгтэй байна.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сургуулиас дэмждэг, докторантурт суралцахад, сургалтын төлбөрийн дэмжлэг олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн 2016-2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөний зорилт 4-т МУИС-ийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хүний хөгжлийг хангах, багш, ажилтны тасралтгүй хөгжих орчин бүрдүүлж, идэвх санаачилгатай ажиллах хөшүүрэг бий болгоно гэж

тодорхойлсон. Энэ дагуу “шилдэг багшлах бүрэлдэхүүнийг бүрдүүлэх” бодлогыг баримталж байна.

- Багш нарын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор бие даасан судалгааны санхүүжилтийн журмыг батлан, мөрдөж байна.
- Доктор багшийн эзлэх хувь өндөр бөгөөд, залгамж халаагаа бэлдэх тал дээр анхаарч ажиллаж байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2016 онд Багшийн хөгжлийн төвийг байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн. Багшийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулан, хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлсон.
- Багшийн хөгжлийн төв үйл ажиллагаагаа эхлүүлснээр багшийн заах арга зүйн үнэлгээ сүүлийн жилүүдэд өссөн.
- Багшийг хөгжүүлэх хөтөлбөрт туссан үйл ажиллагааг хэрэгжүүлж, багш нар дотоодод төдийгүй гадаадад мэргэжил дээшлүүлэх боломж нэмэгдсэн.
- Сүүлийн 3 жилд тус хөтөлбөрийн үндсэн 4 багш 100 хувь богино болон дунд хугацааны мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдэд гадагшаа явж хамрагдсан.
- МУИС-ийн багшийн хөгжил, цахим сургалтын төв нь “Faculty Writing Retreats” хөтөлбөрийн хүрээнд судалгааны арга зүйн сургалт, үр дүнтэй багшлахуйн сургалтуудыг зохион байгуулсанаас гадна залуу эрдэмтдийн индэр хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн www.research.num.edu.mn сайт үүсгэн багш нарын эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний ажлыг бүртгэх, гүйцэтгэлийг хянах, эрдэм шинжилгээний ажлын сан үүсгэн, гүйцэтгэлийн чанар болон ахиц дэвшилд судалгаа хийх, судалгааны түвшнийг тодорхойлох боломжтой болсон.
- Багш нар гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад тогтмол хамрагддаг.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, сургалтын дараах үр дүнгийн үнэлгээг хийж хэвших

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС дотооддоо судалгааны төслийн нээлттэй сонгон шалгаруулалт хийдэг болсон.

- Хөтөлбөрийн нийт 4 багш тайлант хугацаанд 21 сая төгрөгийн судалгааны суурь зардлын санхүүжилтийг МУИС-иас авсан.
- 2016 – 2020 онд гадаад санхүүжилттэй 7 төслийг хэрэгжүүлж, түүний үр дүнд орчуулгын бүтээл, онлайн контент, судалгааны өгүүлэл гарсанаас гадна сургалтын орчинг сайжруулах тал дээр том ахиц гарсан байна.
- Тайлант хугацаанд багш нар ОУ-д 8, дотоодод 8 өгүүлэл хэвлүүлсэний зэрэгцээ зохиогчийн эрхийн гэрчилгээ 1, ном, сурах бичиг, гарын авлага 15, орчуулгын ном 20 – ийг гаргажээ.
- Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурлуудад 22 илтгэл хэлэлцүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр судалгаа, эрдэм шинжилгээний ажлын хувийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Гадаадын их, дээд сургуулийн профессоруудтай хамтарсан судалгааг өргөжүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллаж байна.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр дотооддоо үнэлгээ хийж үзэн, сул талтай байсан чиглэлүүдэд сүүлийн жилүүдэд хүч төвлөрүүлэн ажилласан.
- Багш нар 100 хувь эрдмийн зэрэг цолтой, судалгааны ажил хийх хүсэл эрмэлзэлтэй байгаа нь тэнхимийн судалгааны ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлж байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн жилийн эхэнд багш бүр ажлаа төлөвлөн тэнхимийн хурлаар танилцуулж, хичээлийн жилийн эцэст тайлангаа тэнхимийн эрхлэгчид өгдөг.
- МУИС-ийн хэмжээнд “Багш нарын аттестатчиллын журам” – г мөрдөж ажилладаг.
- Багшийн ажлыг хөндлөнгөөс үнэлүүлэх зорилгоор суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөндлөнгийн үнэлгээний үр дүнд гаргасан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ тодорхойгүй

Шаардлага:

- Хөндлөнгийн үнэлгээнд дүгнэлт шинжилгээ хийж, цаашид сайжруулах ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргаж хэвших

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэстэй.
- Хөтөлбөрийн хорооны журамтай.
- МУИС-ийн өнөөгийн сургалтын үйл ажиллагааг шинжлэн дүгнэх сургалтын чанарын тогтолцооны бүдүүвч

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс байгуулагдан хөтөлбөрийг үүсгэх, батлуулах, хэрэгжүүлэх, хөндлөнгийн үнэлгээ хийх, сайжруулах талаар заавар чиглэл өгөх , дотоод, гадаадын магадлан итгэмжлэлд ороход удирдлагаар хангах зорилготой.
- МУИС-ийн Ерөнхий хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, тэнхмийн хороо, хөтөлбөрийн дэд хороо (5 хүний бүрэлдэхүүнтэй)-д ажилладаг. Хөтөлбөрийн хорооны журмаар эдгээр хороодын үйл ажиллагааг зохицуулдаг.
- Сиси системээр улирал бүр оюутнаас сургалтын орчин ба хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа авдаг.

Анхаарах асуудал:

- Сиси системээр улирал бүр оюутнаар сэтгэл ханамжийн судалгаа авдаг боловч тухайн хөтөлбөрийн чанарт оюутнууд хэрхэн үнэлгээ өгсөн, үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил төдийлөн хангалттай биш.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж дотооддоо хөтөлбөрийн чанар үр дүнг үнэлдэг тогтолцоог бий болгох.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан (2019 оны төгсөгчдийн мөшгих судалгаа)
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан (2018-2019 оны төгсөгчдийн мөшгих судалгаа)
- МУИС-ийн төгсөх түвшний суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2018-2019 он

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаар тоон судалгаатай
- 2016-2020 онуудад төгссөн төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаатай
- Сүүлийн 5 жилийн хугацаанд 72 оюутан төгссөн, үүнээс 38 буюу 52.8% нь төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанд хамрагдсан. Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн өндөр, сэтгэл хангалуун.
- Хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байранд хөрвөх чадвартай.
- Төгсөгчдийн холбоо 2019 онд байгуулагдсан.
- 1968 оноос хойш Франц хэлний хөтөлбөрөөр төгссөн оюутнуудын бүртгэл, эрдэм шинжилгээний ажлын жагсаалт бүхий ном хэвлэгдсэн.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийн чанарыг үнэлж, баталгаажуулахад оролцогч талуудын санал тулгуурладаг гэх боловч ажил олгогч, төгсөгчдөөс авсан судалгаа болон түүний үр дүнд хөтөлбөр сайжруулсан талаар мэдээлэл байхгүй.

Зөвлөмж:

- Төгсөгчид, ажил олгогчдын судалгааг тогтмолжуулах, судалгааны үр дүнг хөтөлбөрийн чанар, үр дүнг сайжруулахад тусгах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөр 2013 онд 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.
- Гадаадын (АНУ, Канад, АНУ) их дээд сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2013 онд Франц хэл судлал бакалаврын хөтөлбөр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэж, шинжээчийн багийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.
- Хөтөлбөрийн агуулга арга зүйг “Европын холбооны ТАСИС” хөтөлбөрийн “Марко” төслийн хүрээнд шинэчлэн боловсруулсан.
- Европын холбооны гадаад хэлний стандартыг хангасан, хэрэглээн дээр суурилсан “ECHO”, “TENDANCES” сурах бичгийг ашигладаг.

- Франц улсад магистр хамгаалсан болон суралцсан төгсөгчдийн мэдээлэлтэй.

Зөвлөмж:

- Хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн ижил хөтөлбөрийн эрдэмтэд, хөтөлбөрийн олон улсын эксперт шинжээчээр тухайн хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шинжээчийн баг МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн “Гадаад хэл, орон судлал (Франц) D023102” бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтуудтай танилцаж, оролцогч талууд болох ажил олгогч, төгсөгч, суралцагч, багш нарын төлөөлөлтэй уулзаж, ярилцан 2 өдрийн турш сургууль дээр ажиллалаа. Энэхүү хөтөлбөр нь 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэхээр шинжээч ажиллуулсан бөгөөд хөтөлбөрийг 2013 онд анх удаа магадлан итгэмжлүүлсэн байна. Хөтөлбөрийг 2015 онд төгсөгчийн загварт суурилан, төгсөгчдөд олгох мэдлэг, чадвар, хандлагыг цогц байдлаар боловсруулан батлуулснаас гадна суралцагчид чөлөөт сонголтын боломжийг нэмэгдүүлсэн байна. Тус хөтөлбөрийн гол онцлог нь Монголдоо Франц хэлний мэргэжилтэн бэлтгэдэг цор ганц хөтөлбөр бөгөөд хөтөлбөрөөр төгсөгчид нь гол төлөв аялал жуулчлалын салбар, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдэд ажиллаж байна.

Тэнхимийн багш нарын тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч мэргэжлийн гол багш нар 100 хувь докторын зэрэгтэй, судалгаа шинжилгээ идэвхтэй хийдэг болох нь уулзалт болон нотлох баримтуудаас харагдлаа. Элсэгчдийн чансаа өндөр, төгсөгчид болон ажил олгогчид тухайн хөтөлбөрийн үр дүнд сэтгэл хангалуун байгаа нь оролцогч талуудтай уулзах явцад ажиглагдлаа. Суралцах орчны хувьд МУИС-ийн зүгээс бодлогоор шат дараалсан алхмуудыг хийсэн нь үр дүнгээ өгсөн байна хэмээн үзлээ.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангас	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт		1.3		Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгийн хувьд хичээлийн хөтөлбөрт тусгагдсан сургалтын арга зүйн ялгаатай байдлыг тодруулах, хөтөлбөрийн матрицыг хичээл хоорондын уялдаа, олгож буй мэдлэг, чадвар, хандлагыг түвшингээр нь ялган харуулах боломжийг бүрдүүлж, нэгдсэн загвараар боловсруулах шаардлагатай.
2	Сургалтын үйл ажиллагаа				
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин,				
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт		4.5		Хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлт болон хөтөлбөрийн сургалтын болон сургалтаас гадуурх үйл ажиллагааны талаар сургуулийн веб хуудсаар дамжуулан мэдээллийг олон нийтэд хүргэх, цаг тухайд нь мэдээллээ шинэчлэх шаардлагатай.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа				
6	Багшийн үйл ажиллагаа				
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт				
	Бүгд				
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын их сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн “Гадаад хэл, орон судлал (Франц) D023102” бакалаврын хөтөлбөрийг БМИУЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийн матрицыг хичээл тус бүрээр олгохоор зорьж буй мэдлэг, чадвар, хандлагыг түвшинтэй нь харж болохуйц байдлаар боловсруулан хэрэглээнд оруулах.
2. Хичээлийн хөтөлбөрт тусгасан сургалтын арга зүйн нийтлэг болон ялгаатай талуудыг тодруулж, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдэд ашиглагдаж буй арга зүйн ялгааг хичээлийн хөтөлбөрүүдэд тусгах. Үнэлгээний арга зүйг хичээлийн хөтөлбөрт тодорхой болгох.
3. Оролцогч талуудаас гарсан санал дээр тулгуурлан салбар бүрийн орчуулгын онцлогийг хичээлд тусгах тал дээр анхаарч, боломжийг эрэлхийлэх.
4. Төгсөгч, ажил олгогч, суралцагчдаас авч буй сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд хийж буй ажлууд, тэдгээрийн үр дүнгийн талаар талуудад эргэж мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх. Тэнхим өөрийн хөтөлбөрийн үр дүнд нарийвчилсан шинжилгээ хийх тал дээр анхаарч ажиллах.
5. Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагаагаа эрчимжүүлж, төгсөгчдийн олон улсын хөдөлмөрийн зах зээлд гарах боломжийг дээшлүүлэх.
6. Тэнхимийн хүрээнд хийгдэж буй сургалтын шинэчлэл, сургалтаас гадуурх олон төрлийн үйл ажиллагаагаа олон нийтэд цаг алдалгүй мэдээлэх тал дээр анхаарч ажиллах.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг /С.Эрдэнэтуул/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /О.Оюунбилэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... /Б.Оюунцэцэг/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил, мэргэшил	Холбоо барих
1	Болат Алтангүл	Профессор	Франц хэл орон судлал, багш, Орчуулга	99141501
2	Лхамсүрэн Дорждэрэм	Дэд профессор	Монгол-франц хэлний багш, Толь судлал Монгол судлал	99080455
3	Сангидхорлоо Булгантамир	Дэд профессор	Франц хэл, олон улсын харилцаа Багш Хэл шинжлэл	99105475
4	Намсрай Мөнх	Ахлах багш	Франц хэл, судлал, Багш, орчуулга	91011511

II. Оюутны нэрс

№	Овог, нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар
1	Э. Энэрэл	2	Улаанбаатар	99978151
2	Б. Өлзийтогтох	2	Булган	95500810
3	О. Эмүжин	2	Улаанбаатар	95541150
4	Э. Мягмарсүрэн	2	Говь Сүмбэр	89866118
5	Л. Намуун	3	Улаанбаатар	85580044
6	Г. Тэмүүлэн	3	Улаанбаатар	95773124
7	О. Оюу-Эрдэнэ	3	Улаанбаатар	99220048
8	Б. Ариунтунгалаг	4	Улаанбаатар	99227720
9	Б. Номинзул	4	Төв аймаг	99652489
10	Э. Даваажаргал	4	Дорноговь	91877028
11	Т. Цолмон	4	Улаанбаатар	85545275
12	Б. Чимэд	4	Улаанбаатар	99706545
13	Э. Энэрэл	4	Улаанбаатар	80054321
14	Б. Оюунсүрэн	4	Баянхонгор	89022880
15	А. Уугангэрэл	4	Дорнод	89608560

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог, нэр	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	П. Лхагвасүрэн	менежер	“Монголий Вояж” ХХЗ	99186952
2	Г. Тунгалаг	менежер	“ДМД” ХХК	99818200
3	Д. Оюунгэрэл	захирал	“Тогтвортой ноолуур”	99069199
4	Б. Ням-Эрдэнэ	менежер	“БАЗ интернэшнл”	89990877
5	Б. Одонмаа	дэд захирал	Монгол-Францын төв	96208388
6	Д. Батцогт	захирал	“Урга тур” ХХК	99995680
7	Ч. Оюунтогос	захирал	Эрүүл мэндийн төслүүд	98118879
8	Д. Далайжаргал	захирал	“Мон Атом”	99110163
9	Э. Наранцэцэг	менежер	“JC Decaux”	99902257

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог, нэр	Төгс сөн он	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	Б. Марал	2021	Франкофон карьер хөгжлийн төвийн ассистант, ОУ судлалын магистрант	МУИС	89963377
2	Л. Оюу-Эрдэнэ	2021	Гадаад хэлний боловсролын магистрант	МУИС	99235254
3	Б. Дүүрэнтуяа	2021	Копирайтер	Юнител Групп	95079937
4	Г. Уранчимэг	2020	Магистрант-ESFAM (Etablissement Spécialise de la Francophonie pour l'Administration et le Management)	Болгар Улс	(+359) 8790 85176
5	А. Анхзаяа	2020	Төслийн менежер	Мөнх харилцаа ТББ	94973889
6	А. Золбадрах	2019	Хэлний туршилт, судалгааны төвийн ассистант, Программ хангамжийн магистрант	МУИС	88982402
7	Э. Тунгалаг	2019	Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Атташе	Гадаад харилцааны яам	99620088
8	Х. Ананд	2015	Францын ЭСЯ-ны Монгол дахь Кампус Францын төлөөлөгч, Монгол-Францын төвийн соёлын төсөл хариуцаж ажилладаг	Францын ЭСЯ-ны Монгол дахь Кампус Франц, Монгол-Францын төв	91162714

9	Б. Цэцэгбаяр	2019	Ерөнхий нарийн бичгийн даргын туслах	ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	95500130
10	Б.Дуламдорж	2016	Ерөнхий менежер	Advest ХХК	88554411, 11320022
11	Д.Амарзаяа	2017	Менежер	Ecovoyage	99919218, 88102170
12	Содцэцэг	2018	Хэвлэл, мэдээллийн мэргэжилтэн	ШЭСЗ ТББ	95143272

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: sas@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2027.12.06 № 76/690

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Европ судлалын тэнхимийн Гадаад хэл, орон судлал (Франц) бакалаврын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайлантай танилцлаа.

Сургууль болон хөтөлбөрийн зүгээс шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрч, цаашид хөтөлбөрийн үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ
САЛБАР ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ  П.ДЭЛГЭРЖАРГАЛ



334000878